

2 Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх

Төрийн байгууллагын соёл болон төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх нь тус зөвлөлийн чиг үүрэгт хамааралтай үүрэг, зорилтын нэг билээ.

Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бүртгэн нэгтгэх, шинжилгээ, дүгнэлт хийх замаар төрийн албан хаагчдын ёс зүйн боловсрол, соёлыг дээшлүүлэх чиглэлээр анхааран ажиллаж ирлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг 2013 оны бүтэн жилийн байдлаар авч нэгтгэн ажиллалаа.


Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороод 2013 онд нийт 118 ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэсэнийг дараах байдлаар танилцуулж байна.

Үүнд:

Хүснэгт 7

2013 он	Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэл					Ёс зүйн зөрчлийг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр				Ёс зүйн зөрчлийг анх буюу давтан үйлдсэн	
	Журмын 1.2		Журмын 2.2.5			Сахилгын шийтгэлийн төрөл				Анх	Давтан
	Гомдлоор	Мэдээллээр	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мөрөөр	Ёс зүйн хорооны санаачилгаар	Байгууллагын удирдлагын шийдвэрээр	ТАТХ-ийн 26.1.1	ТАТХ-ийн 26.1.2	ТАТХ-ийн 26.1.3	Ёс зүйн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж шийдвэрлэсэн		
Удирдах ажилтан	5	1	-	2	4	2	5	2	3	10	2
Гүйцэтгэх ажилтан	18	10	5	14	59	55	33	11	7	79	27
НИЙТ	23	11	5	16	63	57	38	13	10	89	27
	118					118				118	

Ёс зүйн зөрчлийг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулан үзвэл
Зураг 9



2013 оны ёс зүйн болон Салбар зөвлөлүүдийн мэдээнээс үзэхэд ёс зүйн хороодын үйл ажилагаа болон ёс зүйн мэдээ өмнөх хоёр жилийнхтэй харьцуулан үзэхэд 15-20 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Ёс зүйн хороодын үйл ажиллагааг идэвхижүүлэх, сургалт зөвлөгөөг сайтар өгөхөд анхаарч ёс зүйн хэсэгчилсэн сургалтуудыг Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институтээрээ дамжуулан зохион байгуулах талаар энэ онд онцгойлон анхаарч ажиллахаар төлөвлөж байна.